



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 88

Шивээговь сум

Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, тохижилт,
хог хаягдал гаргасны төлбөрийн талаар
албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн
дагаж мөрдөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, Хог хаягдалын тухай хуулийн 8-р зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, тохижилт, хог хаягдал гаргасны төлбөрийн талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам"-ыг хавсралт -1-ээр баталсугай.


2. "Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ"-г хавсралт – 2-оор баталсугай.

3. Журмын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хуралд тайлагнахыг Засаг дарга /С.Ягаанцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 10-р сарын 13-ний өдрийн 33 тоот "Журам батлах тухай" тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ



**Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт, тохижилт, хог хаягдал гаргасны
төлбөрийн талаар албан байгууллага аж ахуйн нэгж иргэдийн
дагаж мөрдөх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс сумын тохижилт, нийтийн эзэмшлийн талбайг арчлан хамгаалах орчноо цэвэр байлгах талаар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, түүнийг мөрдөхөд энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журмыг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, байнга болон түр оршин сууж буй бүх иргэн дагаж мөрдөнө.

1.3. Журмыг сумын ЗДТГ, сум, багийн Засаг дарга нар хариуцан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

**Хоёр. Хог хаягдал, тохижилтын талаар албан байгууллага,
аж ахуйн нэгжийн нийтлэг эрх, үүрэг**

Албан байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн харъяаллаас үл хамааран орчны тохижилтын талаар дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

2.1. Хог хаягдлын талаарх олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах.

2.2. Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

2.3. Хог хаягдлаа хуваарийн дагуу тээвэрлээгүй, ачаагүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагад цаг тухайд нь арга хэмжээ авахыг шаардах.

2.4. Байгууллага бүр ажиллагсдын хэвийн ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч, тохижилт үйлчилгээг хариуцсан байгууллагатай хамтран ажиллах.

2.5. Өөрийн байрны баталгаажсан эдэлбэр газраас гадна эзэмшлийн талбайгаас гадагш 50 метр нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, цас мөсийг тогтмол цэвэрлэж хальтиргаа, гулгаа үүсгэхгүй, орчныг бохирдуулахгүй цэвэр байлгах.

2.6. Байгууллагууд нь хөрш зэргэлдээ байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хаяа нийлсэн байрлалын байдлаас хамааран хоорондоо сул чөлөөтэй буюу эзэнгүй талбай үлдээхгүй байхаар тооцож газраа хуваарилан цаашид хэрхэн тохижуулах асуудлаа хамтран шийдвэрлэсэн байх.

2.7. Байгууллага нь орчноо тохижуулахдаа мэргэжлийн байгууллага, холбогдох этгээдийн зөвлөгөө авч, орчны барилгажилттайгаа нягт уялдуулан аль болох гадаад үзэмжээ сайжруулах, хаяг, рекламаа стандартын дагуу шинэчлэх, гэрэлтүүлэгтэй болгох, гадна орчноо бүрэн гэрэлтүүлсэн байх зэрэг шаардлагуудыг хангаж ажиллах.

2.8. Байгууллага бүр орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчилж ургуулах, хэрвээ ногоон байгууламжгүй бол өөрийн эзэмшиж буй нийт талбайн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний газарт ногоон байгууламжийг заавал бий болгох ажлыг зохион байгуулах.

2.9. Орчноо тохижуулах сумын тохижилтод оруулж буй хувь нэмрээ олон нийтэд сурталчилах ажлыг байгууллага бүр байнга хийж бусдыгаа үлгэрлэх, байгууллагын гадна тохижилт, өнгө үзэмжээ дээшлүүлэх.

2.10. Хог хаягдал гаргасны төлбөрийг цаг хугацаанд нь тогтмол төлж мэргэжлийн байгууллагаар хог хаягдлаа тээвэрлүүлэх.

2.11. Байгууллага бүр гадна талбайдаа стандартын шаардлага хангасан хогийн савтай байх.

2.12. Бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж нь сумаас зохион байгуулж байгаа нийтийн цэвэрлэгээний ажилд хамт олноо идэвхитэй оролцуулах 7 хоног бүр гадна орчноо цэвэрлэж байх.

2.13. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нийтийн эзэмшлийн гудамж талбайд аливаа төвлөрсөн баяр ёслол, үзвэр үйлчилгээний арга хэмжээг зохион байгуулахдаа дэг журамтай, хог хаягдал гаргуулахгүй, орчны ариун цэврийг чанд сахиж нийтийн эзэмшлийн эд зүйлийг хамгаалах.

Гурав. Иргэдийн нийтлэг эрх, үүрэг

Суманд байнга болон түр оршин сууж байгаа бүх иргэд доорх эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

3.1. Хог хаягдлын талаар энэхүү журмын 2.1, 2.2, 2.3, 2.4-т заасан эрхийг эдлэхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

3.2. Энэхүү журамд өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан өөрчлөлт оруулах саналаа өгөх.

3.3. Иргэд нь сумын нутаг дэвсгэрт байгаа ногоон байгууламж, гэрэлтүүлэг, хөшөө дурсгал, зам талбай, хашаа хайс, хүүхдийн тоглоом зэрэг нийтийн эзэмшлийн талбайг хайрлан хамгаалж, зориулалтын бус газар, гудамж талбайд ил задгай хог хаяж зөрчил гаргасан иргэдэд шаардлага тавих, зөрчлийг цаг алдалгүй холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж байх.

3.4. Айл өрх бүр орон сууц, орц, гэр хашааныхаа өнгө үзэмжийг сайжруулж гэрэлтүүлэг, нэгдсэн хаяг, дугаартай болох, стандартын шаардлагад нийцсэн бие засах газар, бохир усны цооногтой байх, 16 насанд хүрсэн иргэн бүр хашаандаа 1-ээс доошгүй мод тарих.

3.5. Сум, багаас зохион байгуулж байгаа их цэвэрлэгээний ажилд идэвхитэй, тогтмол оролцож байх.

3.6. Мал амьтдыг хариулга, хяналтгүй явуулж, хот суурингийн төв, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайд оруулахгүй байх.

3.7. Гэр хорооллын айл өрх, иргэд хог хаягдлаа гудамж талбайд хаяхгүй, хуваарьт өдөр нь ачуулж, хог хаягдал гаргасны төлбөрөө сар бүр хугацаанд нь тогтмол төлж байх.

3.8. Зохих байгууллагын зөвшөөрөл, шинжилгээгүйгээр нохой муур зэрэг гэрийн тэжээвэр амьтад тэжээхгүй байх, гадна орчинд бие засуулахгүй байх, мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх.

Дөрөв. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа

4.1. Албан байгууллага, ААН, айл өрхийн хог хаягдлыг ЗДТГ хариуцан ачиж зайлуулна.

4.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдал хадгалах түр цэгийг байгууллагын гадна байгуулна.

4.3. Орон сууцны айл өрхүүдээс гарсан хог хаягдлыг тус байрнуудын гадна байрлах хог хаягдал хадгалах саванд хадгалж хогны машинаар төвлөрсөн цэгт 7 хоногт 3 удаа зөөж тээвэрлэнэ.

4.4. Гэр хорооллын айл өрхүүд болон төвийн зарим дэлгүүрүүдийн хог хаягдлыг хог тээврийн машинаар 7 хоногт 2 удаа тээвэрлэх ажлыг зохион байгуулна.

Тав. Хог хаягдал гаргасны төлбөр

5.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдал гаргасны төлбөр төлнө.

5.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдал гаргасны төлбөрийг орон нутгийн орлогын 220300995 тоот дансанд сар бүрийн 25-ны дотор төвлөрүүлж байна.

5.3. Орон нутгийн орлогод төвлөрсөн хөрөнгийг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, хог хаягдлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд зарцуулна.

5.4. Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдал гаргасны төлбөрийн хэмжээг энэхүү журмын хавсралтаар батлах бөгөөд шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулж болно.

779

**Зургаа. Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд дараах
үйл ажиллагаа явуулахыг хориглоно.**

6.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр суваг, шуудуу ухах, зам, гудамж талбайг сэтлэх, түүний урсгал чиглэлийг өөрчлөх, ногоон байгууламж, гэрэлтүүлгийг эвдэж сүйтгэх.

6.2. Реклам, сурталчилгааны самбар, зарлал, ухуулах хуудас, хаягийг зөвшөөрөлгүйгээр дур мэдэн гудамж, талбай, байшин барилгын хана туурга, холбоо, гэрлийн шон дээр наах, байрлуулах.

6.3. Хог хаягдал, бохир усыг зориулалтын газар тогтоосон цэгээс өөр газарт ил задгай хаях, шатаах.

6.4. Гудамж талбай, гуу жалга, үзвэр үйлчилгээний газар, орон сууцны орц, хонгилд ил задгай хог хаях.

Долоо. Хүлээлгэх хариуцлага


7.1. Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Эзэмшил газрынхаа болон хариуцсан нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог, цаас, хальтиргаа гулгааг цэвэрлээгүй албан байгууллага, аж ахуйн нэгжид багийн Засаг дарга нар эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцно.

7.3. Зориулалтын бус газар хог хаягдал хаясан, хог шатаасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу шийтгэл ногдуулж, учруулсан хохирлыг арилгуулах

7.4. Бэлтгэсэн хадлан, хашсан бэлчээр, тариалангийн талбай, ногоон байгууламжид мал, тэжээвэр амьтан оруулах, гишгүүлэх, идүүлэх зэргээр тарьц суулгац устгасан, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

Сумын ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн № 88 дугаар тогтоолын хавсралт-2



ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдал гаргах эх үүсвэрүүд		Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ сард /төгрөгөөр/
1	Орон сууцны өрх	Энгийн хог хаягдал	Өрх	2000
2	Гэр хороололын өрх		Өрх	2500
3	Эмнэлэг, амралт, сувиллын газар		Сард	20000
4	Ерөнхий боловсролын сургууль		Сард	15000
5	Хүүхдийн цэцэрлэг, ясли		Сард	10000
6	Өрхийн үйлдвэрлэл (Талх нарийн боов, зайрмаг, хэрчсэн гурил, г.м)		Сард	5000
7	Төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага	5 хүртэл хүнтэй	Сард	5000
		5-20 хүртэл хүнтэй	Сард	10000
		21-с дээш хүнтэй	Сард	15000
8	Нийтийн хоол, гуанз цайны газар		Сард	10000
9	Зочид буудал	10 хүртэлх ортой	Сард	10000
		11-ээс дээш ортой	Сард	15000
10	Ресторан, бар кафе	20 хүртэлх суудалтай	Сард	10000
		21-ээс дээш суудалтай	Сард	15000
11	Шатахуун түгээх станц		Сард	15000
12	Авто засварын газар, Дугуй засвар		Сард	8000
13	Орон сууцанд байрлалтай орон сууцны хог цуглуулах цэгт хаягдлаа байршуулдаг газрууд (Гутал засвар, оёдлын газар, интернэт, тоглоомын газар, зурагчин, компьютерийн үйлчилгээ г.м)		Сард	5000
14	Эмийн сан		Сард	8000
15	Зах, томоохон худалдааны төв, ахуй үйлчилгээний байгууллага	7 хүртэлх түрээслэгчтэй	Сард	15000
		8-10 хүртэлх түрээслэгчтэй	Сард	20000
		11-ээс дээш түрээслэгчтэй	Сард	30000

16	Дэлгүүр	Тусгай зөвшөөрөлтэй	40мкв хүртэл	Сард	10000
			41-ээс дээш мкв	Сард	15000
		Тусгай зөвшөөрөлгүй	40мкв хүртэл	Сард	8000
			41-ээс дээш мкв	Сард	12000
17	Барилгын материал, барааны дэлгүүр		Сард	5000	
18	Жижиглэн худалдаа /ГҮЦ/ түүнтэй дүйцэхүйц жижиг худалдаа		Сард	5000	
19	Үйлдвэрлэл	Нүүрсний уурхай		Сард	100000
		Баяжуулах үйлдвэр		Сард	100000
		Уурын дулаан	зуух,	Сард	50000
		Мал нядалгаа, бойны газар		Сард	25000
20	Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардал		1 тонн	12600	
21	Малчин өрх		Сард	1000	
22	Сумын төвд малтай, мал бүхий өрх		Сард	3000	
23	Халуун усны газар	3 хүртэлх өрөөтэй		Сард	5000
		3-аас дээш өрөөтэй		Сард	8000
24	Үсчин, гоо сайхан, массажны газар		Сард	5000	